



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

АУДИТЫН КОД: АХГ-2022/07/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Долгоржав
Утас: 261628 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

1. Агуулга	
1. Агуулга.....	1
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	19
3.8 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	19
3.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт.....	20
4.3.1 Балансын данстай холбоотой асуудал.....	21
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УИХ	Улсын Их Хурал
ТЭЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
СХЗГ	Стандарт, хэмжил зүйн газар
СХЗХ	Стандарт, хэмжил зүйн хэлтэс
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.25 № 07/706
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Стандарт, хэмжил зүйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Стандарт, хэмжил зүйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар залруулагдаагүй 619.3 сая төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.4, нийцсэн бөгөөд зохистой байх, Эрх ба үүрэг, Тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,567,871.4	2,661,393.5
МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,390.7	6,529.2
АВЛАГА	140,829.0	1,901,715.8
УРЬДЧИЛГАА	50,418.2	0.0
БАРАА МАТЕРИАЛ	1,367,433.5	753,148.5
НӨӨЦИЙН БАРАА	800.0	0.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,922,567.4	7,705,520.8
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,922,567.4	7,705,520.8
Биет хөрөнгө	6,336,457.3	7,076,871.5
Биет бус хөрөнгө	586,110.1	628,649.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>8,490,438.8</u>	<u>10,366,914.3</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	54,589.2	22,051.6
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	54,589.2	22,051.6
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,435,849.6	10,344,862.7
Засгийн газрын хувь оролцоо	8,435,849.6	10,344,862.7
Хуримтлагдсан үр дүн	-536,869.2	1,381,456.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,065,787.5	2,056,475.2
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>8,490,438.8</u>	<u>10,366,914.3</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	<u>13,463,464.1</u>	<u>12,678,337.2</u>
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,921,586.8	5,879,128.8
Нийтлэг татварын бус орлого	7,921,586.8	5,879,128.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,829,520.8	6,799,208.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	<u>12,431,281.8</u>	<u>10,028,993.4</u>
УРСГАЛ ЗАРДАЛ	12,431,281.8	10,028,993.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,927,486.1	7,329,257.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,456,597.5	4,442,646.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	588,498.6	593,079.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	358,365.6	352,172.6
Хангамж, бараа материалын зардал	340,447.2	330,095.5
Нормативт зардал	121,575.7	96,659.0
Эд хогшил, урсгал засварын зардал	193,569.3	173,532.0
Томилолт, зочны зардал	165,710.3	136,268.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,869,500.2	244,277.1
Бараа үйлчилгээний бусад зардал	833,221.7	962,491.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,503,795.8	2,697,770.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	<u>1,319,825.7</u>	<u>2,649,343.9</u>
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	765,273.2	791,768.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	<u>554,552.5</u>	<u>1,857,575.5</u>

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	<u>11,170,951.0</u>	<u>11,727,514.8</u>
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,394,119.8	4,917,647.8
Нийтлэг татварын бус орлого	5,394,119.8	4,917,647.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,776,831.1	6,809,867.0
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	<u>10,663,084.0</u>	<u>11,260,558.3</u>
УРСГАЛ ЗАРДАЛ	10,663,084.0	11,260,558.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,434,219.1	7,003,273.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,449,159.8	4,456,220.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	595,202.9	595,257.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	374,623.4	345,383.5
Хангамж, бараа материалын зардал	255,764.6	249,843.0
Нормативт зардал	162,009.3	155,860.4
Эд хогшил, урсгал засварын зардал	951,765.1	336,007.8
Томилолт, зочны зардал	167,473.8	139,319.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	277,093.0	365,823.6
Бараа үйлчилгээний бусад зардал	201,127.2	358,557.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,228,864.9	4,257,284.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>507,866.9</u>	<u>466,956.4</u>
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	502,175.3	468,818.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	502,175.3	468,818.0
Дотоод эх үүсвэрээр	502,175.3	468,818.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-502,175.3	-468,818.0
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>5,691.6</u>	<u>-1,861.5</u>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,699.1	8,390.7
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,390.7	6,529.2

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,141,469.4	0.0	7,141,469.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	6,545.9	0.0	6,545.9
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,148,015.3	0.0	7,148,015.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	7,282.1		7,282.1
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	725,999.6	0.0	725,999.6
Тайлант үеийн үр дүн	554,552.6	0.0	554,552.6
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,435,849.6	0.0	8,435,849.6
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	60,749.8	0.0	60,749.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,496,599.4	0.0	8,496,599.4
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-9,312.3	0.0	-9,312.3
Тайлант үеийн үр дүн	1,857,575.6	0.0	1,857,575.6
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,344,862.7	0.0	10,344,862.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,223,872,700.00	7,949,567,424.49	274,305,275.51	96.7
УРСГАЛ ЗАРДАЛ	8,223,872,700.00	7,949,567,424.49	274,305,275.51	96.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,494,234,700.00	7,233,851,089.03	260,383,610.97	96.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,485,373,100.00	4,447,683,996.64	37,689,103.36	99.2
Үндсэн цалин	3,340,847,100.00	3,286,482,626.70	54,364,473.30	98.4
Нэмэгдэл	929,168,000.00	936,645,716.89	-7,477,716.89	100.8
Унаа хоолны хөнгөлөлт	215,358,000.00	222,743,778.45	-7,385,778.45	103.4
Урамшуулал	0.00	1,662,716.96	-1,662,716.96	-
Гэрээт ажлын хөлс	0.00	149,157.64	-149,157.64	-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	624,465,100.00	595,718,626.14	28,746,473.86	95.4
Тэтгэврийн даатгал	444,819,500.00	443,964,163.91	855,336.09	99.8
Тэтгэмжийн даатгал	44,911,300.00	38,083,418.17	6,827,881.83	84.8
ҮОМШӨ-ний даатгал	35,929,400.00	29,679,517.26	6,249,882.74	82.6
Ажилгүйдлийн даатгал	8,982,000.00	9,875,404.79	-893,404.79	109.9
Эрүүл мэндийн даатгал	89,822,900.00	74,116,122.01	15,706,777.99	82.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	375,768,800.00	345,383,491.88	30,385,308.12	91.9
Гэрэл, цахилгаан	96,202,000.00	71,646,406.19	24,555,593.81	74.5
Түлш, халаалт	192,738,900.00	191,227,805.21	1,511,094.79	99.2
Цэвэр, бохир ус	32,368,600.00	32,303,800.48	64,799.52	99.8
Байрны түрээс	54,459,300.00	50,205,480.00	4,253,820.00	92.2
Хангамж, бараа материалын зардал	254,782,400.00	250,372,986.71	4,409,413.29	98.3
Бичиг хэрэг	49,596,900.00	51,113,162.00	-1,516,262.00	103.1
Тээвэр, шатахуун	79,399,100.00	79,146,613.00	252,487.00	99.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	58,638,800.00	57,612,111.71	1,026,688.29	98.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,727,400.00	5,160,290.00	1,567,110.00	76.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	60,420,200.00	57,340,810.00	3,079,390.00	94.9
Нормативт зардал	162,093,000.00	156,641,658.00	5,451,342.00	96.6
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	151,762,500.00	151,741,158.00	21,342.00	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,330,500.00	4,900,500.00	5,430,000.00	47.4
Эд хогшил, урсгал засварын зардал	807,001,000.00	689,194,327.28	117,806,672.72	85.4
Багаж, техник, хэрэгсэл	566,177,600.00	471,853,267.00	94,324,333.00	83.3
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	24,590,000.00	16,610,627.28	7,979,372.72	67.6
Урсгал засвар	216,233,400.00	200,730,433.00	15,502,967.00	92.8
Томилолт, зочны зардал	152,341,400.00	139,731,290.00	12,610,110.00	91.7
Дотоод албан томилолт	152,341,400.00	139,731,290.00	12,610,110.00	91.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	316,085,800.00	295,232,861.50	20,852,938.50	93.4

Стандарт, хэмжил зүйн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил үйлчилгээний төлбөр хураамж	155,410,100.00	154,480,495.50	929,604.50	99.4
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,233,600.00	3,452,380.00	1,781,220.00	66.0
Даатгалын үйлчилгээ	8,558,600.00	8,036,263.00	522,337.00	93.9
Тээврийн хэрэгслийн татвар	2,867,200.00	1,484,708.00	1,382,492.00	51.8
Тээврийн хэрэгслийн оношлогоо	588,900.00	488,300.00	100,600.00	82.9
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	21,157,200.00	21,003,725.00	153,475.00	99.3
Газрын төлбөр	6,696,200.00	5,450,710.00	1,245,490.00	81.4
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,020,000.00	201,080.00	818,920.00	19.7
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	114,554,000.00	100,635,200.00	13,918,800.00	87.8
Бараа үйлчилгээний бусад зардал	316,324,100.00	313,891,850.88	2,432,249.12	99.2
Бараа үйлчилгээний бусад зардал	272,222,900.00	270,838,089.88	1,384,810.12	99.5
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	44,101,200.00	43,053,761.00	1,047,439.00	97.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	729,638,000.00	715,716,335.46	13,921,664.54	98.1
Засгийн газрын гадаад шилжүүлэг	275,232,600.00	266,706,081.46	8,526,518.54	96.9
Засгийн газрын гадаад шилжүүлэг	275,232,600.00	275,232,600.00	0.00	100.0
Бусад урсгал шилжүүлэг	454,405,400.00	449,010,254.00	5,395,146.00	98.8
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	435,045,400.00	430,158,274.00	4,887,126.00	98.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,360,000.00	18,851,980.00	508,020.00	97.4
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,223,872,700.00	8,223,872,700.00	0.00	100.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,650,335,900.00	4,650,335,900.00	0.00	100.0
Улсын төсвөөс санхүүжих	4,650,335,900.00	4,650,335,900.00	0.00	100.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,573,536,800.00	3,573,536,800.00	0.00	100.0
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,573,536,800.00	3,573,536,800.00	0.00	100.0
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	293,001.00		
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	1,855,400.00		
БАЙГУУЛЛАГЫН ТОО	21	21	0	100.0
Төсвийн байгууллага	21	21	0	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	375	375	0	100.0
Удирдах ажилтан	28	28	0	100.0
Гүйцэтгэх ажилтан	231	231	0	100.0
Үйлчлэх ажилтан	116	116	0	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	375	375	0	100.0
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	204	204	0	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	171	171	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,195,349,057.60
УРСГАЛ ЗАРДАЛ		2,194,749,057.60
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		269,429,255.33
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		8,536,714.14
Үндсэн цалин		8,536,714.14
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		538,389.86
Тэтгэврийн даатгал		538,389.86
Нормативт зардал		200,000.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		200,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал		105,295,202.00
Багаж, техник, хэрэгсэл		44,473,400.00
Тавилга		44,386,583.00
Урсгал засвар		16,435,219.00
Томилолт, зочны зардал		425,000.00
Дотоод албан томилолт		425,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		76,690,749.33
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		69,860,449.33
Мэдээлэл, технологийн үйлчилгээ		6,757,500.00
Газрын төлбөр		72,800.00
Бараа үйлчилгээний бусад зардал		77,743,200.00
Бараа үйлчилгээний бусад зардал		66,550,850.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		11,192,350.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,925,319,802.27
Бусад урсгал шилжүүлэг		372,166,920.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		372,166,920.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		1,553,152,882.27
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг		1,553,152,882.27
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		600,000.00
Дотоод эх үүсвэрээр		600,000.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		600,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		2,195,349,057.60
Нэмэлт санхүүжилтийн орлого		2,195,349,057.60
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		7,100,000.00
ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		19,014,948.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,894,059,088.60
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		275,175,021.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Стандарт, хэмжил зүйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримтын бүрдүүлэлтийг сайжруулах, баталсан төсвийг зохистой удирдаж, үр ашигтай зарцуулах, тендерийг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, гэрээний ажлын гүйцэтгэлийг бүрэн хангуулж ажиллах талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хооронд ахлах аудитор Б.Долгоржав гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Г.Гүнжидмаа, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Сарансүх нар хэрэгжүүлсэн.

Стандарт, хэмжил зүйн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/163 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Стандарт, хэмжил зүйн газар “Монгол Улсын хөгжлийн стратеги, чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж, экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогоор дэмжлэг үзүүлэхэд оршино” гэж үйл ажиллагааны эрхэм зорилгоо тодорхойлжээ.

Дээрх эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр байна. Үүнд:

Төрийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх, зохицуулалтыг хангах, гадаад харилцаа, хамтын ажиллагааг эрхэлсэн асуудлаараа олон улс, бүс нутаг, гадаад орны хүрээнд өргөжүүлэх;

Стандартчилал, тохирлын үнэлгээ, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хууль тогтоомжийг боловсронгуй болгоход санал боловсруулах, бодлого, стратегийг төлөвлөх, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах, гүйцэтгэлд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх;

Стандартчилал, тохирлын үнэлгээ, техникийн зохицуулалтын хөтөлбөр, төсөл боловсруулах, техникийн зохицуулалтыг олон улсын жишгээр бий болгоход дэмжлэг үзүүлэх, тэдгээрийн төсөлд шүүлт хийх, эдгээр чиглэлийн дүрэм, журам, заавар, удирдамжаар хангах;

Хэмжлийн нэгжийн олон улсын системд тулгуурласан үндэсний эталоны тогтолцоог хөгжүүлэх, нарийвчлалыг олон улсын түвшинд ойртуулах, үндэсний эталоноос нэгж дамжуулах тогтолцоог сайжруулан бэхжүүлэх;

Итгэмжлэлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, зохицуулалтыг хангах, олон улсын итгэмжлэлийн байгууллагаар итгэмжлүүлэх;

Сорьцын хяналтын тогтолцоог боловсронгуй болгох, сорьцын лабораторийн чадавхыг дээшлүүлэх

Олон улсын гэрээ хэлэлцээр, олон улс, бүс нутаг, гадаад орны болон үндэсний стандарт, тохирлын үнэлгээ, техникийн зохицуулалт болон холбогдох норматив техникийн баримт бичгээс бүрдсэн үндэсний мэдээллийн сан бүхий төрийн мэдээллийн нөөц болох албыг байгуулан хөгжүүлэх;

Бүтээгдэхүүн үйлчилгээ, тогтолцооны баталгаажуулалтыг олон улсын жишигт хүргэж, хөгжүүлэх;

Хэмжих хэрэгслийн баталгаажуулалтыг улсын баталгаажуулалтад заавал хамрагдах хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын түвшинг дээшлүүлэх, баталгаажуулалтын ажлын чанарыг олон улсын түвшинд ойртуулах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль тогтоомж, бодлого, чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн батлах тухай 190 дүгээр тушаал;
- Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоол;
- Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль;

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хүрээнд зохион байгуулалтын 8 нэгж, 6 аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санхүү, нягтлан бодох бүртгэлд илэрсэн зөрчлийг давтахгүй ажиллах, алдаа, дутагдлаас урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө өгч ажилласан боловч хэрэгжилт хангалтгүй байна. Сангийн яамнаас 2021 онд шалгалт хийсэн боловч шалгалтын тайланг эцэслэн ирүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Стандарт, хэмжил зүйн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд ерөнхий материаллаг байдлын түвшнийг 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 3,636.0 сая төгрөгөөс 36.4 сая төгрөгөөр тогтоож баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд ерөнхий материаллаг байдлын түвшнийг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын дүн 10,243.7 сая төгрөгөөс 1.0 хувиар тооцож 102.4 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 8.4 сая, эцсийн үлдэгдэл 6.5 сая төгрөг болж, 1.9 сая төгрөгөөр буурсан нь ахмадын сангийн хөрөнгөтэй холбоотой байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	0.0	836.5	836.5
Төрийн сангийн харилцах дансанд	8,097.7	5,692.7	-2,405.0
Арилжааны банкн дахь харилцах дансанд	293.0	0.0	-293.0
Дүн	8,390.7	6,529.2	-1,861.5

Эх сурвалж: Стандарт, хэмжил зүйн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл нь Дундговь, Баянхонгор аймгийн СХЗХ-ийн ахмадын сангийн хөрөнгө, Баян-Өлгий аймгийн СХЗХ-ийн томилолтын зөрүүний буцаалтын мөнгө байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн СХЗХ-ийн даргын 2021 оны А/22 дугаар тушаалаар ажилчдад 1.7 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгохдоо ажилчдаас НДШ-ийн 0.2 сая, ХХОАТ-ын 0.1 сая, нийт 0.3 сая төгрөгийг суутган тооцоогүй;
- СХЗГ - анхан шатны баримтын бүрдэл дутуу 71.5 сая төгрөгийн гүйлгээг Төрийн сангийн гүйлгээ хаагдах өдөр хийсэн, 14.3 сая төгрөгийн гэрээт ажлын гүйцэтгэлийн актгүй;
- Дорноговь аймгийн СХЗХ ;йт 8.6 сая төгрөгийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан;
- Баян-Өлгий аймгийн СХЗХ байрны түрээс төлбөрт 18.0 сая төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 140.8 сая, эцсийн үлдэгдэл 1,901.7 сая төгрөг болж, 1,760.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Сангийн сайдын тушаалаар зарцуулах эрх үүссэн, 2021 оны үндсэн үйл ажиллагааны давсан орлогыг төвлөрүүлсэнтэй холбоотой авлага 1,553.1 сая төгрөг, эталон тоног төхөөрөмж худалдан авахаар шилжүүлсэн 207.8 сая төгрөг байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	10,869.3	6,145.5	-4,723.8
Төлбөртэй үйлчилгээний авлага	62,831.7	92,054.0	29,222.3
Татаас, санхүүжилтийн авлага	12,630.5	1,553,102.2	1,540,471.7
Бусад авлага	54,497.5	250,414.1	195,916.6
Дүн	140,829.0	1,901,715.8	1,760,886.8

Эх сурвалж: Стандарт, хэмжил зүйн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын үлдэгдэлд Стандарт, хэмжил зүйн газрын 1,684.5 сая, Баянхонгор аймгийн СХЗХ-ийн 67.8 сая, Сүхбаатар аймгийн СХЗХ-ийн 13.8 сая, Дархан-Уул аймгийн СХЗХ-ийн 12.1 сая төгрөгийн авлага байна.

Хүснэгт №3 Авлагын насжилт / мянган төгрөг /

Үзүүлэлт	0-1 жил	1-2 жил	3-4 жил
Ажиллагсадтай холбогдсон авлага	4,535.3	1,610.2	0.0
Төлбөртэй үйлчилгээний авлага	53,538.1	38,515.9	0.0
Татаас, санхүүжилтийн авлага	1,553,102.2	0.0	0.0
Бусад авлага	219,536.0	20,142.8	10,735.3
Дүн	1,830,711.6	60,268.9	10,735.3

Эх сурвалж: Стандарт, хэмжил зүйн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын үлдэгдлийн 11.0 сая төгрөг Ховд аймгийн СХЗХ-ийн хувь хүнээс авах шүүхийн шийдвэртэй 3-4 жилийн насжилттай, 60.1 сая төгрөгийн байгууллагаас авах баталгаажуулалтын үйлчилгээний өмнөх онд, 1,830.6 сая төгрөгийн татаас, санхүүжилтийн болон хөрөнгө бэлтгэхтэй холбоотой авлага тайлант онд үүссэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Авлагын үлдэгдэлд 3-4 жилийн насжилттай СХЗГ 28.3 сая, нэгээс дээш жилийн насжилттай Говь-Алтай аймгийн СХЗХ 0.9 сая, Орхон аймгийн СХЗХ 0.3 сая төгрөгийн авлага;
- Баянхонгор аймгийн СХЗХ 4.6 сая төгрөгийн грашийн барилгыг бариагүй байхад авлагыг хааж, дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэсэн.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны 50.4 сая төгрөгийн эхний үлдэгдлээс Дорнод аймгийн СХЗХ 24.6 сая, Дархан-Уул аймгийн СХЗХ 20.3 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн авсан, Хэнтий аймгийн СХЗХ 5.5 сая төгрөгийн урьдчилгааг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэж, үлдэгдэлгүй болсон байна.

Хүснэгт №4 Урьдчилгаа дансны үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	5,500.0	0.0	-5,500.0
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	44,918.2	0.0	-44,918.2
Дүн	50,418.2	0.0	-50,418.2

Эх сурвалж: Стандарт, хэмжил зүйн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 1,367.4 сая, эцсийн үлдэгдэл 753.2 сая төгрөг болж, 614.2 сая төгрөгөөр буурсан нь Дорнод аймгийн СХЗХ-ийн дуусаагүй барилгыг үндсэн хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт №5 Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	1,140,297.6	432,605.7	-707,691.9
Тусгай зориулалттай материал	250,288.3	320,855.5	70,567.2
Эм боох материал	18,313.5	30,649.8	12,336.3
Дуусаагүй үйлдвэрлэл	772,231.9	0.0	-772,231.9
Бэлэн бүтээгдэхүүн	99,463.9	81,100.4	-18,363.5
Хангамжийн материал	227,135.8	320,542.8	93,407.0
Бичиг хэргийн материал	26,664.9	32,433.8	5,768.9
Аж ахуйн материал	168,322.0	257,604.6	89,282.6
Сэлбэг хэрэгсэл	2,077.0	2,630.0	553.0
Түлш, шатах тослох материал	7,616.1	10,554.4	2,938.3
Барилгын засварын материал	5,528.7	1,524.0	-4,004.7
Бусад хангамжийн материал	16,927.1	15,796.0	-1,131.1
Дүн	1,367,433.4	753,148.5	-614,284.9

Эх сурвалж: Стандарт, хэмжил зүйн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалын 57.4 хувийг түүхий эд материал, 42.6 хувийг хангамжийн материал эзэлж байна.

Тайлант онд бараа материал төсвийн хөрөнгөөр худалдан авсан 692.3 сая, хандиваар 2.1 сая, шилжүүлэн авсан 12.0 сая, бусад 14.5 сая, бүтцийн өөрчлөлтөөр 0.4 сая, нийт 721.3 сая төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 546.3 сая, шилжүүлсэн 773.9 сая, бусад 16.2 сая, нийт 1,336.4 сая төгрөгөөр буурчээ.

Түүхий эд материалын үлдэгдэл өмнөх оноос 82.9 сая, хангамжийн материал 93.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тусгай зориулалтын буюу шинжилгээний химийн бодис, стандарт боловсруулалтын бичиг хэргийн хэрэгсэл, түлш шатах тослох материалуудыг их хэмжээгээр худалдан авснаас нөөц үүсгэсэн байна. Тухайлбал: Баянхонгор аймгийн СХЗХ 13.8 сая, Өвөрхангай аймгийн СХЗХ 4.9 сая, Дорнод аймгийн СХЗХ 4.5 сая, Өмнөговь аймгийн СХЗХ 4.3 сая, Орхон аймгийн СХЗХ 4.1 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Булган аймгийн СХЗХ бараа материалын дансанд хангамж, аж ахуй, хүнс, тусгай зориулалтын материал болон эм, бэлдмэл зэрэг нийт 13.4 сая төгрөгийн бүх төрлийн материалыг нэг дансанд бүртгэсэн;
- Сэлэнгэ аймгийн СХЗХ 7.7 сая төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй;
- Төв аймгийн СХЗХ 0.7 сая төгрөгийн шатах, тослох материалын нөөц бэлтгэсэн, 0.8 сая төгрөгийн шатах, тослох материалын тооцоог бодоогүй.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл цэвэр дүнгээр 14,441.5 сая, эцсийн үлдэгдэл 15,357.3 сая төгрөг болж, 915.7 сая төгрөгөөр өссөн нь Дорнод аймгийн СХЗХ оффисын барилгыг бүртгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт №6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	13,786,140.9	14,701,295.8	915,154.9
Барилга, байгууламж, орон сууц	5,720,091.2	6,602,725.1	882,633.9
Авто-тээврийн хэрэгсэл	502,919.4	502,919.4	0.0
Машин тоног төхөөрөмж	6,824,245.4	6,811,219.2	-13,026.2
Тавилга, аж ахуйн эд хогшил	568,829.1	628,835.5	60,006.4
Зам, гүүрийн байгууламж	3,500.0	3,500.0	0.0
Бусад үндсэн хөрөнгө	159,885.0	145,425.8	-14,459.2
Ном	6,670.8	6,670.8	0.0
Биет бус хөрөнгө	655,403.2	655,984.8	581.6
Програм хангамж	169,884.6	170,066.2	181.6
Бусад биет бус хөрөнгө	485,518.6	485,918.6	400.0
Дүн	14,441,544.1	15,357,280.6	915,736.5

Эх сурвалж: Стандарт, хэмжил зүйн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт хөрөнгөөс барилга, байгууламж 69.6 хувь, тоног төхөөрөмж 17.6 хувь, бусад биет бус хөрөнгө 6.3 хувь, тавилга, эд хогшил 2.4 хувь, программ хангамж 1.9 хувь, тээврийн хэрэгсэл 1.4 хувь, ном 0.1 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 468.8 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 774.3 сая, үнэ төлбөргүй хандиваар 22.7 сая, бусад 194.2 сая, дахин үнэлгээний нэмэгдэл 12.3 сая, нийт 1,472.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, балансаас баланст шилжүүлсэн 0.4 сая, акталсан 468.3 сая, бусад 63.3 сая, дахин үнэлгээний хорогдол 24.5 сая, нийт 556.5 сая төгрөгөөр хасагдсан ба тайлант хугацаанд 730.3 сая төгрөгийн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн зардал гарсан байна.

Аудитын илрүүлэлт:

- СХЗГ 19.6 сая төгрөгийн хөрөнгийг ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүй, 19.4 сая төгрөгийн хөрөнгийг зарлагын эдийн засгийн ангилал зөрүүлэн зарцуулсан;
- Завхан аймгийн СХЗХ жилийн эцсийн тооллогын бүртгэлийн 6.0 сая төгрөгийн хөрөнгийг баталгаажуулаагүй;

- Дундговь аймгийн СХЗХ үндсэн хөрөнгийн тооллогын дүнг санхүүгийн байдлын тайлан, хөрөнгийн тооллогын бүртгэлээс зөрүүтэй баталгаажуулсан;
- Дархан-Уул аймгийн СХЗХ жилийн эцсийн тооллогын дүн санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн дүнгээс 5.4 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн;
- Дорнод аймгийн СХЗХ санхүүгийн тайлан үндсэн хөрөнгийн дүн болон Өмч хамгаалах комиссын хагас жилийн тооллогын дүн 5.4 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан;
- Үндсэн хөрөнгө дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 79.0 сая төгрөгийн хөрөнгө байна. Үүнд: Дорноговь аймгийн СХЗХ 65.6 сая, Ховд аймгийн СХЗХ 13.4 сая, Сүхбаатар аймгийн СХЗХ 23.8 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 54.6 сая, эцсийн үлдэгдэл 22.1 сая төгрөг болж, 32.5 сая төгрөгөөр буурсан нь СХЗГ татварын өглөг, Төв аймгийн СХЗХ санхүүгийн шалгалтын актыг барагдуулсантай холбоотой байна.

Хүснэгт №7 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон өглөг	4,245.5	1,255.4	-2,990.1
Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,219.9	0.0	-1,219.9
Байгууллагад төлөх өглөг	46,877.2	17,707.0	-29,170.2
Хувь хүмүүст төлөх өглөг	2,246.6	3,089.2	842.6
Дүн	54,589.2	22,051.6	-32,537.6

Эх сурвалж: Стандарт, хэмжил зүйн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт богино хугацаат өр төлбөрийн 80.1 хувийг байгууллагад төлөх, 14.0 хувийг хувь хүмүүст өгөх, 5.9 хувийг ажилчидтай холбогдсон өглөгүүд эзэлж байна. Өр төлбөрийн данстай холбоотой дараах зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн СХЗХ ажилтнуудын цалингаас НДШ-ийг бүрэн суутгасан боловч НДХ-т 0.5 сая төгрөгөөр дутуу мэдээлж, санхүүгийн тайланд 0.1 сая төгрөгийн өглөгөөр бүртгэсэн.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 8,435.9 сая, эцсийн үлдэгдэл 10,344.9 сая төгрөг болж, 1,909.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

Хүснэгт №8 Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	6,906,931.3	6,906,931.3	0.0
Хуримтлагдсан үр дүн	-536,869.2	1,381,456.2	1,918,325.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,065,787.5	2,056,475.2	-9,312.3
Дүн	8,435,849.6	10,344,862.7	1,909,013.1

Эх сурвалж: Стандарт, хэмжил зүйн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.8 Орлогын данс

Тус салбарын үндсэн үйл ажиллагааны орлого нь гадаад, дотоод худалдааны үйл ажиллагааг эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн бүтээгдэхүүн ажил үйлчилгээнд болон хэмжих хэрэгсэлд тохируулга, шалгалт баталгаажуулалт олгох, үнэт металлын сорьц тогтоох, баталгаажуулах, гулдмайлах, үнэт эдлэл, эрдэнийн чулуу тодорхойлох, Монгол Улсын болон орчуулгын стандартыг боловсруулах зэргээс бүрддэг байна.

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн СХЗХ төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 01/604 тоот албан бичгээр үндсэн үйл ажиллагааны давсан орлогыг Төрийн сангийн дансанд төвлөрүүлэх үүрэг өгсөн байхад 0.1 сая төгрөгийг төвлөрүүлээгүй;
- Булган аймгийн СХЗХ байгууллагын орлогыг няравын хувийн дансаар авч, шимтгэлийн орлогыг дутуу тайлагнасан;
- Өмнөговь аймгийн СХЗХ үйл ажиллагааны давсан орлогоос албан хаагчдад олгосон нэг удаагийн тэтгэмж урамшууллаас 17.0 сая төгрөгийн НДШ, ХХОАТ суутгаж тооцоогүй байна.

3.5.9 Зардлын данс

Тайлант оны үндсэн үйл ажиллагаанаас 7,016. сая төгрөгийн орлогын 60.6 хувь буюу 4,252.6 сая төгрөгийг зардлаар бүртгэсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Ховд амьгийн СХЗХ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч үйчлэгч, сахиулыг хууль зүйд нийцээгүй эрх зүйн акт гаргаж, ажлаас чөлөөлснийг 3 шатны шүүхийн шийдвэрээр тогтоосон бөгөөд үүнтэй холбоотой нийт 15.0 сая төгрөгийг байгууллагын төсвөөс нөхөн олгосон;
- Завхан амьгийн СХЗХ төрийн алба хаасан хугацааны болон ур чадварын нэмэгдлийг 0.4 сая, Дундговь аймгийн СХЗХ албан томилолтыг 0.2 сая төгрөгөөр илүү олгосон;
- Булган аймгийн СХЗХ 1.8 сая төгрөгийг гарын бэлэг, шагнал урамшуулалд зарцуулсан;
- Хэнтий аймгийн СХЗХ орон сууцанд амьдарч байгаа албан хаагчдад түлээ нүүрсний хөнгөлөлтөд 0.9 сая төгрөгийг олгосон;
- Дархан-Уул аймгийн СХЗХ урамшууллын зардлаас аймгийн Засаг даргын 2021 оны 01-А/200 дугаар захирамжаар хэлтсийн дарга 1.1 сая, хэлтсийн даргын 2021 оны А/01 тушаалаар хүний нөөцийн ажилтны цалинг илүү тогтоож 2.3 сая, Б/20 дугаар тушаалаар 4 ажилтанд нүүрсний хөнгөлөлтөд 0.4 сая төгрөгийг олгосон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зарлагыг 8,512,5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 8,565.5 сая төгрөгөөр баталж, тодотголоор 341.6 сая төгрөгөөр бууруулан, 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 8,223.9 сая төгрөгөөр тодотгосон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,650.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 3,573.5 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,696.8 сая төгрөгийн санхүүжилтийг авч, үндсэн үйл ажиллагааны орлогод 4,911.2 сая төгрөгийг бүрдүүлсэн нь баталсан төсвөөс 1,337.7 сая төгрөгөөр давуулсан байна. Тайлант онд үнэт металлын сорьц, хэмжих хэрэгсэл, шалгалт тохируулга, экспорт, импорт, дотоодын бүтээгдэхүүний баталгаажуулалт, стандарт борлуулалтын орлоготой холбоотой байна.

Хүснэгт №9 Үйл ажиллагааны орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого	3,573,536.8	4,911,187.2	1,337,650.4	137.4
Нийт дүн	3,573,536.8	4,911,187.2	1,337,650.4	137.4

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7,949.6 сая төгрөг буюу 96.7 хувьтай байна. Томилолтын зардлын төсвийг 12.6 сая, бараа үйлчилгээний бусад зардлын төсвийг 20.8 сая, байр ашиглалтын зардлын төсвийг 30.4 сая, эд хогшил урсгал засварын зардлын төсвийг 117.8 сая төгрөгийг дутуу зарцуулсан байна.

Улсын төсвийн санхүүжилтээс 953.5 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 658.7 сая, нийт 1,612.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №10 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70407	Стандарчилал, хэмжил зүй	8,223,872.7	7,949,567.4	274,305.3	96.7
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	7,338,824.6	7,079,370.6	259,454.0	96.5
1.2	80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	93,930.1	93,404.9	525.2	99.4
1.3	80219	Харуул, хамгаалалтын зардал	49,480.0	49,075.6	404.4	99.2
1.4	80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	12,000.0	12,000.0	0.0	100.0
1.5	80509	Гадаадын болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж	275,232.6	266,706.1	8,526.5	96.9
1.6	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	454,405.4	449,010.2	5,395.2	98.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламж 7.1 сая, Засаг даргын нөөц хөрөнгөөс 19.0 сая, дээд шатны төсвийн захирагчаас 1,996.0 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 173.2 сая, нийт 2,195.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэн 642.1 сая төгрөгийг зарцуулж, 1,553.2 сая төгрөгийг улсын төсвийн дансанд татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд стандарт, хэмжилт, баталгаажуулалтын салбарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан 7 зорилтын хүрээнд 37 арга хэмжээг төлөвлөн, 96.3 хувийн үнэлгээтэй хэрэгжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 23 дугаар тогтоолыг үндэслэн Үндэсний итгэмжлэлийн төвд балансаас баланст шилжүүлсэн хөрөнгийн 47.3 сая төгрөг, Дундговь, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Увс зэрэг аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсүүдийн үндсэн хөрөнгө, бараа материалыг дахин үнэлүүлж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолоор бүртгэсэн байна.

3.9 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүрээнд 2021 онд шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 18,170.4 сая төгрөгийн 434 ажил гүйлгээг байршуулахаас, 598.1 сая төгрөгийн 31 орлого, зарлагын гүйлгээг хугацаа хоцроон байршуулжээ.

3.8 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 9.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 76.4 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 953.6 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж хүргүүлсэн бөгөөд хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт №11 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	1	9,600.0		9,600.0	-	-	100.0
Албан шаардлага	2	76,400.0		76,400.0	-	-	100.0
Зөвлөмж	4	953,600.0		798,700.0	1	-	83.7
Нийт	7	1,039,600.0	5	1,039,600.0	1	-	94.6

3.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тайлант онд татан төвлөрүүлсэн 1,554.2 сая төгрөгөөр 2022 онд тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авахаар төлөвлөгөөг боловсруулсан байна. Иймд татаас, санхүүжилтийн авлагын буюу нэмэлт санхүүжилтийн хөрөнгийн зарцуулалтыг дараагийн аудитаар шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 21 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэсэн бөгөөд 4 байгууллагыг аудитын түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамруулсан 15 байгууллагад Зөрчилгүй, Баянхонгор, Завхан аймгийн СХЗХ-т Хязгаарлалттай дүгнэлт өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 367.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 214.7 сая төгрөгийн алдааг залруулан, 67.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага, 85.8 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлээ.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар 713.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 94.2 сая төгрөгийн алдааг залруулан, 20.8 сая төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 82.7 сая төгрөгийн 18 зөрчлийг арилгах албан шаардлага, 515.8 сая төгрөгийн зөрчилд 31 зөвлөмж хүргүүлсэн байна.

Залруулагдаагүй 619.3 сая төгрөгийн алдаа, зөрчил нь тогтоосон 102.4 сая төгрөгийн ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Харьяа байгууллагуудын 2021 оны аудит хийсэн санхүүгийн тайланг зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Хөвсгөл аймгийн СХЗХ-үүдийн үндсэн үйл ажиллагааны давсан орлогыг төвлөрүүлсэн 154.8 сая төгрөг, Стандарт, хэмжил зүйн газар нь Сангийн сайдын тушаалаар давсан орлогыг зарцуулахдаа харьяа байгууллагуудад үүссэн өр төлбөрийг барагдуулах зорилгоор шилжүүлсэн 35.8 сая төгрөг, нийт 190.7 сая төгрөгийн гүйлгээг мөнгөн гүйлгээний тайлангаас, харьяа байгууллагуудад олгосон үнэт цаас, тооцоот маягтын 24.0 сая төгрөгийн давхардсан ажил гүйлгээг санхүүгийн үр дүнгийн тайлангаас устгах бичилтийг хийж залруулсан.

4.2 Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн албан шаардлага

1. Авлагын дансанд Акуатус ХХК-аас авах 10.5 сая төгрөгийн, Дэд бүтэц инженеринг ХХК-аас авах 17.8 сая төгрөгийн 3-4 жилийн насжилттай авлагын үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг барагдуулах тодорхой арга хэмжээ авч ажиллах, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

2. Тайлант онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрөлгүй 19.6 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлын төсвөөс 19.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тус тус бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 1.2 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалд заасан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын дагуу зарцуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгө бэлтгэхдээ ТӨБЗГ-аас зөвшөөрөл авах, урсгал төсвөөс хөрөнгө бэлтгэхгүй байх, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

3. Харьяа орон нутгийн байгууллагуудын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 619.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, өмнөх оны аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн дүнгээс 2.5 дахин их байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасныг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

4.3 Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн зөвлөмж

4.3.1 Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны баримтын бүрдэл дутуу, тендерийн сонгон шалгаруулалтгүйгээр 71.5 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдэлийг хангах, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, төсвийн хэмнэлтийн талаарх тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах.

4.3.2 Гэрээт ажлын гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 14.3 сая төгрөгийн гэрээт ажлын гүйцэтгэлийн болон ажил хүлээлцсэн акт үйлдээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гэрээний хэрэгжилт болон гүйцэтгэлийг хангуулж, гэрээний биелэлтийг дүгнэн, ажлыг хүлээлцэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Стандарт, хэмжил зүйн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

/мянган төгрөгөөр/

№	Шалгагдагч байгууллагын нэр	Аудитын код	Аудитын санал дүгнэлтийн төрөл					Нийт алдаа, зөрчлийн дүн				Үүнээс				Зөвлөмж		
			Бүгд	Зөрчллийн	Хязгарлалттай	Сөрөг	Саналдүгнэлт өгөхөөс татгалзсан	Түвэгт хамрагдсан	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага	
													Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Стандарт, хэмжил зүйн газар	АХГ-2022/07/НА-СТА-ТТЗ						+	5	339,504.0	2	214,700.0			1	39,004.0	2	85,800.0
2	Архангай аймгийн СХЗХ	АРА-2022/20/-НА-СТА-ТТЗ	+	+					3	7,727.0	1	4,000.0			2	3,727.0		
3	Баян-Өлгий аймгийн СХЗХ	БӨА-2022/16/1/ НА-СТА-ТТЗ	+	+					1	18,000.0							1	18,000.0
4	Баянхонгор аймгийн СХЗХ	БНА-2022/104/НА-СТА-СШЗ			+				8	123,469.7	4	28,297.0	3	5,058.0			1	90,114.7
5	Булган аймгийн СХЗХ	БУА-2022/133/НА-СТА-ТТЗ	+	+					4	3,242.7			1	220.0			3	3,022.7
6	Говь-Алтай аймгийн СХЗХ	ГАА-2022/67/-НА-СТА-ТТЗ	+	+					3	13,543.5	2	12,643.5			1	900.0		
7	Дархан-Уул аймгийн СХЗХ	ДАА-2022/125/НА-СА-ТТЗ	+	+					2	3,819.7							2	3,819.7
8	Дорноговь аймгийн СХЗХ	ДОА-2022/168/НА/СТА-ТТЗ						+	2	74,170.2					1	8,570.2	1	65,600.0
9	Дорнод аймгийн СХЗХ	ДГА-2022/158/НА-СТА-ТТЗ	+	+					1	5,400.0							1	5,400.0
10	Дундговь аймгийн СХЗХ	ДУА-2022/09/НА-СТА-ТТЗ						+	5	4,723.7	2	4,376.10	1	185.0	2	162.7		
11	Завхан аймгийн СХЗХ	ЗАА-2022/203/СТА-ТТЗ			+				4	7,084.0	2	748.00	1	350.0	1	5,986.0		
12	Орхон аймгийн СХЗХ	ОРА-2022/26/НА-СТА-ТТЗ	+	+					4	840.9	1	400.0			1	175.6	2	265.3
13	Өвөрхангай аймгийн СХЗХ	ӨВА-2022/116/НА-СТА-ТТЗ	+	+					1	200.0					1	200.0		
14	Өмнөговь аймгийн СХЗХ	ӨМА-2022/110/НА-СТА-ТТЗ	+	+					5	35,240.1	2	14,602.9					3	20,637.2
15	Сүхбаатар аймгийн СХЗХ	СУА-2022/31/НА-СТА-ТТЗ						+	1	0.0							1	0.0
16	Сэлэнгэ аймгийн СХЗХ	СЭА-2022/256/НА-СТА-ТТЗ	+	+					1	1,136.0							1	1,136.0
17	Төв аймгийн СХЗХ	ТӨА-2022/20/-НА-СТА-ТТЗ	+	+					3	30,585.9	1	29,130.9			1	705.0	1	750.0
18	Увс аймгийн СХЗХ	УВА-2022/54/НА-СТА-ТТЗ	+	+														
19	Ховд аймгийн СХЗХ	ХОА-2022/32/НА-СТА-ТТЗ	+	+					1	13,445.7							1	13,445.7
20	Хөвсгөл аймгийн СХЗХ	ХГА-2022/244/НА-СТА-ТТЗ	+	+					1	0.0	1							
21	Хэнтий аймгийн СХЗХ	ХЗА-2022/13/НА-СТА-ТТЗ	+	+														
Санхүүгийн аудитаар			21	15	2			4	55	682,133.1	18	308,898.4	6	5,813.0	11	59,430.4	20	307,991.3

Стандарт, хэмжил зүйн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

№	Шалгагдагч байгууллагын нэр	Аудитын код	Аудитын санал дүгнэлтийн төрөл					Нийт алдаа, зөрчлийн дүн				Үүнээс								
			Бүгд	Зөрчллийн	Хязгаарлалттай	Сөрөг	Саналдүгнэлт өгөхөөс татгалзсан	Түгээрт хамрагдсан	Тоо	Дүн	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
													Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Стандарт, хэмжил зүйн газар																			
2	Архангай аймгийн СХЗХ	АРА-2022/20/-НА-СТА-ТШЗ								28,310.0	2			28,310.0	2			1	0.0	
3	Баян-Өлгий аймгийн СХЗХ	БӨА-2022/161/ НА-СТА-ТШЗ								51,803.0	2			51,803.0	2			2	31,984.60	
4	Баянхонгор аймгийн СХЗХ	БНА-2022/104/НА-СТА-СШЗ								31,984.6	2									
5	Булган аймгийн СХЗХ	БУА-2022/133/НА-СТА-ТШЗ								1,800.0	1			1,800.0	1			1	1,800.0	
6	Говь-Алтай аймгийн СХЗХ	ГАА-2022/67/-НА-СТА-ТШЗ								130,238.7	2				1	0.0		1	130,238.7	
7	Дархан-Уул аймгийн СХЗХ	ДАА2022/125/НА-СА-ТШЗ																		
8	Дорноговь аймгийн СХЗХ	ДОА-2022/168/НА/СТА-ТШЗ																		
9	Дорнод аймгийн СХЗХ	ДДА-2022/158/НА-СТА-ТШЗ								0.0	1							1	0.00	
10	Дундговь аймгийн СХЗХ	ДУА-2022/09/НА-СТА-ТШЗ																		
11	Завхан аймгийн СХЗХ	ЗАА-2022/203/СТА-ТШЗ								1,317.1	1							1	1,317.1	
12	Орхон аймгийн СХЗХ	ОРА-2022/26/НА-СТА-ТШЗ																		
13	Өвөрхангай аймгийн СХЗХ	ӨВА-2022/116/НА-СТА-ТШЗ																		
14	Өмнөговь аймгийн СХЗХ	ӨМА-2022/110/НА-СТА-ТШЗ								109,333.3	1							1	109,333.30	
15	Сүхбаатар аймгийн СХЗХ	СҮА-2022/31/НА-СТА-ТШЗ								0.0	1							1	0.00	
16	Сэлэнгэ аймгийн СХЗХ	СЭА-2022/256/НА-СТА-ТШЗ								7,708.3	2				1	0.0		1	7,708.30	
17	Төв аймгийн СХЗХ	ТӨА-2022/20/-НА-СТА-ТШЗ								1,675.7	2							2	1,675.70	
18	Увс аймгийн СХЗХ	УВА-2022/54/НА-СТА-ТШЗ								0.0	1							1	0.0	
19	Ховд аймгийн СХЗХ	ХОА-2022/32/НА-СТА-ТШЗ								15,020.9	1				1	15,020.9				
20	Хөвсгөл аймгийн СХЗХ	ХГА-2022/244/НА-СТА-ТШЗ								11,400.0	1							1	11,400.0	
21	Хэнтий аймгийн СХЗХ	ХЭА-2022/13/НА-СТА-ТШЗ								8,638.7	3						3	8,638.7		
			21	15	2					399,230.3	24				1	15,020.9	10	90,551.7	13	293,657.7
			79	1	0.0					1,081,363.4	79			7	20,833.9	21	149,982.1	33	601,649.0	
Нийцлийн аудитаар																				
ДҮН			21	15	2					308,898.4	18				7	20,833.9	21	149,982.1	33	601,649.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 670/A0160070

Улаанбаатар хот

АХГ-2022/04/НА-СТА-ТТЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Стандарт, хэмжил зүйн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрөлгүй 19,600,000.00 төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлын төсвөөс 19,404,000.00 төгрөгийн үндсэн хөрөнгийг тус тус бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 1.2 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалд заасан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын дагуу зарцуулаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаарын тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

1. Үндсэн хөрөнгө бэлтгэхдээ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авах, хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Стандарт, хэмжил зүйн газрын дарга Б.Билгүүн, Санхүүгийн хэлтсийн дарга захирал О.Оюунтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Г.ГҮНЖИДМАА

АХЛАХ АУДИТОР

Б.ДОЛГОРЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

9019120396

2: \Alban.Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-300.Docx

0001081629



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 671/А0160040

Улаанбаатар хот

АХГ-2022/07/НБ-СТА-ТТЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Стандарт, хэмжил зүйн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Авлагын дансанд Акуатус ХХК-аас авах 10,523,000.00, Дэд бүтэц инженеринг ХХК-аас авах 17,787,000.00 төгрөгийн 4-5 жилийн насжилттай авлагын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2 "батлагдсан төсөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, даван гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаарын тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч шийдвэрлэх, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид авлага үүсгэхгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Стандарт, хэмжил зүйн газрын дарга Б.Билгүүн, Санхүүгийн хэлтсийн дарга захирал О.Оюунтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Г.ГҮНЖИДМАА

АХЛАХ АУДИТОР

Б.ДОЛГОРЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9010112004966

Alban Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-301.Docx

00010816??



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25 № 672/А0160070

Улаанбаатар хот

АХГ-2022/07/НА-СТА-Т+3

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Стандарт, хэмжил зүйн газрын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харьяа байгууллагуудын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 619,350,990.00 төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

Энэ нь өмнөх оны аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн дүнгээс 2.5 дахин их байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасныг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаарын тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах, илэрсэн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид дотоод хяналтыг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Стандарт, хэмжил зүйн газрын дарга Б.Билгүүн, Санхүүгийн хэлтсийн дарга захирал О.Оюунтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Г.ГҮНЖИДМАА

АХЛАХ АУДИТОР

Б.ДОЛГОРЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-299.Docx

0001081631

